

## **БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ХЭСГИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРМЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус, амьтан, байгалийн ургамал, ойн нөөц ашигласны болон газрын төлбөрийн орлогыг Төсвийн тухай, Татварын ерөнхий хуулийн дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлдэг. Эдгээр төлбөрийн орлогын 15-85 хувиас доошгүй хэсгийг байгалийн орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд хуваарилан зарцуулах харилцааг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-аар зохицуулж байна.

Төсвийн жилд орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого нь нэгдсэн дүнгээр 2012 онд **40** тэрбум байсан бол 2018 онд **86** тэрбум, 2019 онд **94** тэрбум, 2020 онд **112** тэрбум төгрөгт хүрч өсөн нэмэгдсэн. Орон нутгийн байгууллагууд нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу дээрх орлогоос жил бүр **25 – 34** тэрбум төгрөгөөс доошгүй хөрөнгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд хуваарилан зарцуулах байсан ч ердөө **7-15** тэрбум төгрөгийг хуваарилж, харин үлдсэн **16-20** тэрбум төгрөгийн хөрөнгийг байгаль орчинд хамааралгүй арга хэмжээнд захиран зарцуулжээ. Түүнчлэн зарим тохиолдолд төсвийн жилд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого төлөвлөгөөнөөс давж биелдэг боловч эдгээр орлогыг байгаль хамгаалахад зарцуулдаггүй байдал орон нутагт нийтлэг байна. Тухайлбал 2019 онд орон нутгийн төсөвт орох байгаль нөөц ашигласны төлбөрийн орлогыг **76** тэрбум төгрөгөөр төлөвлөсөн боловч төсвийн гүйцэтгэлээр **26.5** тэрбум төгрөгийн орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн бөгөөд энэ хөрөнгө мөн зориулалт бусаар зарцуулагджээ.

Дээрх нөхцөл байдал нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт **30-43** хувь буюу маш хангалтгүй түвшинд байгааг илэрхийлнэ.

“Байгалийн нөөц ашиглагч нь тухайн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг төлдөг байх” үзэл баримтлалд суурилсан Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байх нь нөөцийг урт хугацаанд тогтвортой ашиглах нөхцөл алдагдаж, байгалийн нөөцийн хомсдол, доройтол, цөлжилтийг эрчимжүүлэх сөрөг үр дагавартай. Иймд БОАЖЯ-наас тус хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор хүчин төгөлдөр үйлчилж буй “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын зөрчил, хийдлийг засч шинэчлэн боловсрууллаа.

Журмыг шинэчлэхдээ төсвийн болон хөгжлийн бодлого төлөвлөлтийн эрх зүйн орчинд нийцүүлэх, оролцогчийг тодорхой болгох, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төсвийн шатлалаар ялгаатай тодорхойлох, байгалийн нөөцийн төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан хэсгийг хуулийн дагуу байгаль хамгаалахад зарцуулах, нэгдсэн стандарт маягт ашиглах, процессыг цахимжуулах зарчмыг баримтлав. Иймд шинэчилсэн журмын төслийн зохицуулалтууд нь төсвийн жилд аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос санхүүжүүлэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг оновчтой төлөвлөх, үр дүнг тооцох, зарцуулалтыг ил тод болгох, түүнд хяналт тавих боломж бүрдүүлсэн нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулахад үр нөлөөтэй.

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**